



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/29

Рашаант сум

┌ Захирамжид өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, 31 дүгээр зүйлийн 31.2, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/133 дугаар тушаалын 8.9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын иргэн Нацагдорж овогтой Баттулгын хүсэлтийн дагуу Энхтал багийн Хуурай хөндийн аманд байршилтай 6706003174 нэгж талбарын дугаартай төмс, хүнсний ногооны зориулалттай газрыг 2008 оны 10 дугаар сарын 27-ний өдрийн 93 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 48 дугаар мөрийн 1000 м² гэж алдаатай гаргасан шийдвэрийг 10000 м² болгон засаж үлдсэн 5 жилийн хугацаатайгаар өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 10 дугаар сарын 27-ний өдрийн 93 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 48 дугаар мөрийг хүчингүйд тооцсугай.

3. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал /Б.Ариунжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Т.Отгонцэцэг/-д, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Билэгдэмбэрэл / нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

67060011061